

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ДУНДГОВЬ АЙМАГТ
ХОЛБОГДОЛТОЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2020 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Цагаандэлгэр сум

2020.12.15

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	2020 оны хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО								
Тэргүүлэх зорилт №2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.								
2.26. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	4	“Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	I-IV улирал	-	-	“Монгол малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тэргүүн сүрэг” ХХК-тай гэрээ байгуулан сумын бог малын хээлтүүлэгч, бухыг ээмэглэх ажил зохион байгуулахад 1156200 төгрөг зарцуулан ажиллалаа. Ээмэгний үнийг тухайн компани дансанд 100 хувь төвлөрүүллээ. Мөн бод малыг хэмжих палк метр, бог мал хэмжих палк метр, лентметр, циркуль зэрэг багаж тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэн өгсөн байна.	100
2.35. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт, хяналтыг сайжруулна.	9	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг гаргах, цас, борооны ус тогтоох хөв цөөрөм барьж байгуулах	III-IV улирал	-	-	Шинээр 30-аас доошгүй худаг гаргаж, хөв, цөөрөм барьж байгуулснаар нийт мал сүргийн усан хангамж 1,2 орчим хувиар нэмэгдэх	Суманд гүн өрмийн худаг гаргах байсан боловч төсөвт тусгагдаагүйн улмаас хийгдээгүй байна. Мөн малчид өөрийн хөрөнгөөр энгийн уурхайн 3 худаг сэргээн засварлаж бэлчээр усжуулах арга хэмжээ зохион байгууллаа.	70
2.39. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх	11	Газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, хоршоонд техник,	I-IV улирал	Хувийн хэвшил	20.0	Төмсний үйлдвэрлэлд 12 хувь, хүнсний ногооны	Сумын хэмжээнд 2020 онд 2 ААНэгж, 7 өрх жимс жимсгэнэ 1,71га, төмс 1,4га, хүнсний ногоо 0,6га-д тус тус тариалж төмс 4 тн, нарийн ногоо 3 тн, өргөст хэмх 2,5 тн, чинжүү 0,5тн, бусад ногоо 0,5 тн-	100

бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.		технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, төмс хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх				үйлдвэрлэлд 3 хувьд хүргэх	ыг тус тус хурааж авсан. Хүлэмжийн ногоо тарихаар ЗДТГ, ЭМТ санаачлага гараган 4*8 харицаатай хүлэмж захиалж нарийн ногоо тариалах иргэдэд ногоо тарих боломжийг бүрдүүлсэн.	
ГУРАВ.НИЙГМИЙН БОДЛОГО								
Тэргүүлэх зорилт №3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.								
3.1.18. Хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангах асуудлыг дэмжинэ.	34	Орон нутагт, ялангуяа сумдын эрүүл мэндийн төвийн эмчийг тогтвор суурьшилтай ажиллаж амьдрахад нутгийн засаг захиргааны байгууллагаас дэмжлэг үзүүлэх, орон байраар хангах	III-IV улирал	ОНТ	106.0 сая	1-2 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг орон байраар хангах.	2020 онд ЭМТ-д 2 их эмч, 1 дунд мэргэжилтэн ажиллахаар ирсэн ба 3 ажилтанг нэгдсэн халаалтанд холбосон орон байраар хангасан.	100
Тэргүүлэх зорилт №3.2.3. Соёл урлагийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож соёл урлагийг хөгжүүлэх бодлого, санхүүжилт, удирдлага зохион байгуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлнэ. биеийн тамир, спортын дэд бүтцийг сайжруулан нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.								
3.2.49. Хөдөө орон нутагт хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр дүнтэй уялдуулан соёл урлагийн барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай зохион байгуулна.	42	Зарим дүүргийн соёлын ордон, сумын соёлын төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах	I-IV улирал	УТ	1.655.0	Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусган, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумдын Соёлын төвийн барилгын ажлыг 25-аас дээш хувьтай гүйцэтгэх	Соёлын төвийн 240 хүний суудалтай 2 давхар барилга угсралтын ажил 2020 оны 05 дугаар сард эхлэж, гүйцэтгэгч компаниар “Хэрмэдэй” ХХК ажиллаж байна. 1 давхрын дээврийн хучилт бүрэн хийгдээд байна.	30
Тэргүүлэх зорилт №3.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.								

3.3.3. Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжинэ.	43	Орон нутгийн онцлогийг тусган боловсруулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	I-IV улирал	УТ	120.0	Ажлын байрны тоо -35 Түр ажлын байр -300	Ажил олоход хүндрэлтэй 6 иргэнийг түр ажлын байранд 2 удаа зуучилж ажиллуулсан. Ажил олгогч дэмжих хөтөлбөрт хамрагдсан байгууллага байхгүй.	70
3.3.26. Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ.	44	Сэргээн засах төв, сувилахуйн төв, сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв байгуулах	II-IV улирал	-	-	Ахмадын сувилалаар сэргээн засах үйлчилгээнд хамрагдагсдын тоо -100 Хувийн хэвшлийн байгууллагаар гэрээлэн сэргээн засах үйлчилгээнд хамрагдагсдын тоо -30	7 ахмад настан амралт сувилалд, 8 ахмад настан дотоодын рашаан сувилалд амарч, 60 ахмад, 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 8260.000 төгрөгний ортопедийн хэрэгсэл олгосон.	100
Тэргүүлэх зорилт №3.4. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангана.								
3.4.2. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	47	"Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, хамгааллын тусламж шуурхай үзүүлэх түр хамгаалах байр байгуулах	I-IV улирал	ОНТ	1.2 сая	Гарсан кейсийг бүрэн шийдвэрлэж, Хамтарсан багийн үйлчилгээ тогтмолжих Хүчирхийлэлд өртсөн дунд болон өндөр эрсдэлтэй иргэдэд түр хамгаалах байраар үйлчлэх	Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хамтарсан багийн гишүүдтэй нууцын гэрээг шинээр байгуулсан. Гэр бүл, хүүхдүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хамтарсан багийн гишүүд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон дагаж гарсан нэмэлт дүрмийг судлан танилцаж иргэдэд сурталчилан ажилласан. Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл болон хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан бий болгосон.	100

							Хамтарсан багийн гишүүд сумын хэмжээнд байгаа 12 өрхийн 21 хүүхдэд хүнс тэжээлийн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн.	
Тэргүүлэх зорилт №5.3. Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.								
5.3.7. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	83	Иргэдэд зориулсан эрх зүйн албан бус сургалтыг тогтмолжуулах	II, III улирал	-	-	Иргэдийн эрх зүйн боловсрол дээшлэх	Жилийн хугацаанд Эрх зүйн хөтөч багаас зохион байгуулсан 6 чиглэлийн 145 цахим сургалтыг Дундговь Цагаандэлгэр сумын Насан туршийн боловсрол пэйж хуудсанд байрлуулж давхардсан тоогоор 2982 иргэн, санхүүгийн боловсрол олгох 5 хичээлийг танхимаар явуулж 128 иргэн, эрх зүйн боловсрол олгох 8 сургалтыг 244 иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол олгох 2 сургалтанд 121 иргэн, Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны 13 цахим сургалтыг 918 иргэн, бусад 12 сургалт явуулж нийт 157 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 4150 хүн үзэж суралцсан байна.	100
Тэргүүлэх зорилт №5.4. Чанд сахилга бат, дэг журамд суурилсан хүнлэг, иргэндээ ээлтэй, улсдаа түшигтэй, хууль хэлбэрэлтгүй мөрдөгдсөн хуулийн байгууллагыг бэхжүүлэх зарчмыг баримтална.								
5.4.9. Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна.	84	Аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайн гэрлэн дохионы ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	I-IV улирал	-	-	Гэмт хэрэг, зам тээврийн ослоор нас барах иргэний тоог бууруулах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлын баталгааг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд бодит үр нөлөөг үзүүлэх	Хариуцсан нутаг дэвсгэрт ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа эхлэх үеэр жил бүр иргэд болон хүүхэд багачуудын хөдөлгөөн ихсэхтэй холбоотойгоор замын хөдөлгөөны аюулгүй байдлыг хангах чиглэлээр эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн хяналтыг тогтмол тавьж SCHOOL POLICE, эцэг, эхийн эргүүлийг жил бүр идэвхижүүлэн ажиллаж байна. Мөн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулж эгнээ гудамж, сургууль орчмын бүсэд анхааруулах тэмдэглэгээ хийсэн. Сумын төвөөс урагш Говьсүмбэр аймгийг чиглэсэн том тэрэг	100

							явах чиглэлийн замын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх нэмж байрлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Жил бүр, сумын иргэдийн тээврийн хэрэгслүүдийг улсын үзлэгт хамруулах, дугааргүй тээврийн хэрэгслийг дугааржуулах ажлыг зохион байгуулан ажилласан байна. Сумын мотоцикльтой иргэдийг хамгаалах малгайг тогтмол өмсөж, зүүж хэвшүүлсэн. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “ЯАРААД ЯАХАВ ДЭЭ” аяны хүрээнд хөдөлгөөнд оролцож байгаа иргэдэд хууль эрх зүйн зөвөлгөөг өгч ажилсан.	
ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД								
Адаацаг, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Дэлгэрцогт сумдад соёлын төвийн барилга барина.	92	Цагаандэлгэр суманд соёлын төвийн барилга шинээр барих	I-IV улирал	УТ	655.0	Цагаандэлгэр сумдын соёлын төвийн барилгын угсралтын ажлыг 30 хувь	Соёлын төвийн 240 хүний суудалтай 2 давхар барилга угсралтын ажил 2020 оны 05 дугаар сард эхлэж, гүйцэтгэгч компаниар “Хэрмэдэй” ХХК ажиллаж байна. 1 давхрын дээврийн хучилт бүрэн хийгдээд байна.	30
ХЭРЭГЖИЛТ								81,8

НЭГТГЭСЭН: НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГА
ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА

О.НАНДИН-ЭРДЭНЭ
З.СОЛОНГО
Д.БУДЖАВ